

## “БУМАН БОРГОЦОЙ” ХХК

### СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 32-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ “ХУШ МОДНЫ САМАР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН /АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5991447/



#### **Хянасан:**

БОУАӨЯ-ны ХБОБЗГ-ын шинжээч: \_\_\_\_\_

#### **Танилцсан:**

“Буман боргоцой” ХХК-ийн ерөнхий захирал

С.Жаргалбат

#### **Боловсруулсан:**

“Далангийн хөшөөт” ХХК, гэрээт зөвлөх

Э. Энхжин

Улаанбаатар хот

2024

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1	ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
1.1	Төслийн товч танилцуулга .....	3
1.2	Төслийн байршил .....	4
1.3	Үйлдвэрийн бүтэц, үйл ажиллагаа .....	6
1.4	Төслийн дэд бүтэц .....	7
2	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	8
2.1.1	Агаарын чанар .....	11
2.1.2	Дуу шуугиан .....	11
2.1.3	Гадаргын болон газрын доорх ус .....	12
2.1.4	Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг .....	12
2.1.5	Ойн сан .....	13
3	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	14
4	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	16
5	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	16
6	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	18
7	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	19
7.1.1	Агаарын чанар .....	19
7.1.2	Дуу шуугиан .....	20
7.1.3	Хөрсөн бүрхэвч .....	21
8	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	23
9	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	24
10	ДҮГНЭЛТ .....	24
	ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ .....	26

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл .....	3
Хүснэгт 1.2	Төслийн талбайн байршлын цэгүүд .....	4
Хүснэгт 2.1	Сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	8
Хүснэгт 3.1	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт .....	14
Хүснэгт 4.1	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт .....	16
Хүснэгт 5.1	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	16
Хүснэгт 6.1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	18
Хүснэгт 7.1	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....	19
Хүснэгт 7.2	Үйлдвэрийн гадна талбайн агаарын чанарын шинжилгээний үр дүн, 2024.5.13 .....	20
Хүснэгт 7.3	Үйлдвэрийн дотоод орчны агаарын чанарын хэмжилтийн үр дүн, 2024.5.13 .....	20
Хүснэгт 7.4	Дуу шуугианы хэмжилтийн үр дүн .....	20
Хүснэгт 7.5	Хөрсний үржил шимийн үзүүлэлтүүд .....	21
Хүснэгт 7.6	Хөрсний үржил шимийн суурь үзүүлэлтүүд ба шинжилгээний үр дүнгийн тайлбар .....	21
Хүснэгт 7.7	Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн .....	22
Хүснэгт 8.1	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	23

Хүснэгт 9.1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....	24
Хүснэгт 10.1 2024 оны БОМТ-нд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болон биелэлтээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо .....	25
Хүснэгт 10.2 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал .....	25

### **Зургийн жагсаалт**

Зураг 1.1 Хуш модны самар боловсруулах үйлдвэрийн байршил .....	5
---	---

### **Гэрэл зургийн жагсаалт**

Гэрэл зураг 1.1 Самар боловсруулах үйлдвэрийн байр .....	6
Гэрэл зураг 1.2 Үйлдвэрийн дамжлага .....	6
Гэрэл зураг 2.1 Тээврийн хэрэгсэл байнга зорчдог хэсгүүдийг хайрган болон хатуу хучилттай болгосон байдал .....	11
Гэрэл зураг 2.2 Зүлэгжүүлсэн болон хатуу хучилттай болгосон талбайнууд .....	12
Гэрэл зураг 2.3 Ургамлын бичиглэл хийсэн талбай .....	13
Гэрэл зураг 2.4 Шилмүүст модыг хүлэмжинд үрээр тарьж, гадна талбайд шилжүүлэн суулгасан байдал.....	14
Гэрэл зураг 3.1 Зүлэгжүүлсэн талбай болон үрээр тарьсан хайлаас .....	15

### **Тайлангийн хавсралтууд**

- Ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ
- 2 га талбайд нарс, хуш, шинэс тарих, арчлах гэрээ
- Ахуйн хортон шавьж устгах, ариутгах ажлын гэрээ
- Галын аюулгүй байдлын дүгнэлт
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа
- Гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах гэрээ
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах, тээвэрлэх гэрээ
- Хөрсний дээжлэлт
- Агаарын чанар, дуу шуугиан, хөрсний дээж шинжлүүлсэн лабораторийн шинжилгээний үр дүн

## 1 ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Буман боргоцой ХХК-ийн “Хуш модны самар боловсруулах үйлдвэр” нь Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд өөрийн эзэмшлийн хашаанд үйл ажиллагаагаа явуулж байна. Үйлдвэр нь жилд 3000 тн байгалийн самар боловсруулах хүчин чадалтай ба боловсруулсан эцсийн бүтээгдэхүүний 20 хувийг дотооддоо борлуулах ба үлдсэн 80 хувийг БНХАУ-руу экспортолдог бөгөөд гуравдагч орон руу экспортлохоор төлөвлөсөн.

Тус онд самар бэлтгэх зөвшөөрлийн хугацаанд самрын нөөц багассан байсан тул 2024 онд дуудлага худалдаанд оролцоогүй ба үйлдвэр үйл ажиллагаа явуулаагүй. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/737 дугаар тушаалын хавсралт “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 3.4-т “Хуш модны самрыг 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд бэлтгэнэ” гэж заасан.

### 1.1 Төслийн товч танилцуулга

#### Хүснэгт 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл

#	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Буман Боргоцой” ХХК
	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011554123
	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, аялал жуулчлал
	Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг 32-р хороо, Хайрхан 6-27 тоот
	Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Захирал С.Жаргалбат
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Менежер Б.Алена Утас: - 99066263
1.2	Төслийн нэр	Хуш модны самар боловсруулах үйлдвэр
	Төслийн харьяаллын байршил	“Хуш модны самар боловсруулах төсөл” нь Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, Хайрхан 6-27 тоотод байрлана. Эзэмшил талбайн нийт хэмжээ нь 0.9921,0 м <sup>2</sup> .
	Төслийн ангилал	Үйлдвэрлэл
	Төсөл эхэлсэн огноо	2015 он
	Төсөл хэрэгжих хугацаа	Хугацаагүй
	ТЭЗҮ баталсан огноо	-
	Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	-
	Ажилчдын тоо	35
	Галын дүгнэлтийн огноо, дугаар	№2024737 2021/08/10
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт-, БОАЖЯ, 2021 он

	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	“Хос Нахиа” ХХК, 2021 он
--	--	--------------------------


## 1.2 Төслийн байршил

“Буман боргоцой” ХХК-ийн “Хуш модны самар боловсруулах үйлдвэр” нь Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар-баруун аймгуудыг холбосон хатуу хучилттай автозамаас урагш 1 км зайд байрладаг (Хүснэгт 1.2).

### Хүснэгт 1.2 Төслийн талбайн байршлын цэгүүд

#	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	106	41	34.6	47	53	20.8
2	106	41	39.0	47	53	23.6
3	106	41	48.1	47	53	25.0
4	106	41	49.7	47	53	23.4
5	106	41	38.8	47	53	16.4

Зураг 1.1 Хуш модны самар боловсруулах үйлдвэрийн байршил



### 1.3 Үйлдвэрийн бүтэц, үйл ажиллагаа

Үйлдвэр нь самрыг хатаах, шигших, цөмж яснаас салгах, дахин үлээлгэх, самрын идээг хатаах, хальсыг ялгах зориулалт бүхий тоног төхөөрөмжүүдтэй. Үйлдвэр нь жилд 3000 тн байгалийн самар боловсруулах хүчин чадалтай, үйлдвэрийн хашаанд 1,260 м<sup>2</sup> талбай бүхий хуш модны самар боловсруулах үндсэн үйлдвэр, боловсруулаагүй самар хадгалах 700 тн-ийн багтаамжтай, бэлэн болсон бүтээгдэхүүн хадгалах 500 тн-ын агуулах, хатаалгын 4 цехтэй, 300 м<sup>2</sup> талбай бүхий оффисын барилга болон ажилчдын амрах байртай. Тус үйлдвэр нь нийт 35 ажилтантай.

Гэрэл зураг 1.1 Самар боловсруулах үйлдвэрийн байр



Гэрэл зураг 1.2 Үйлдвэрийн дамжлага

Самрыг хальснаас салгах машин



Самрын идээг хатаах машин



Хагас боловсруулсан самрын идээ



#### 1.4 Төслийн дэд бүтэц

- Усан хангамж: Ажилчдын ундны усыг 1 тн-ын саваар “Жэ эйч жэй мандухай” ХХК-ийн гүний худгаас зөөвөрлөн хангадаг.
- Цахилгаан хангамж: цахилгааны төвлөрсөн эх үүсвэрээс
- Дулаан хангамж: Тениэр.



## 2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### Хүснэгт 2.1 Сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

#	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
<b>Агаарын чанар</b>					
1	Тоосжилт үүсэх, агаар дахь түгээмэл бохирдуулагч бодисуудаар агаар бохирдох	Үйлдвэрийн гадаах орчны тоосжилт болон агаар дахь түгээмэл бохирдуулагч бодисуудыг хянах, бууруулах	Орчны тоосжилт болон агаар дахь түгээмэл бохирдуулагч бодисуудын хэмжээг хянаж, бууруулахын тулд ОХШХ-ийн дагуу Агаарын чанарын дээж авах, шинжлүүлэх ажлыг Цаг уур орчны шинжилгээний газрын “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”-р гүйцэтгүүлсэн.	(252,000) ОХШХ-ийн Агаарын чанарын биелэлтийн зардалд тусгагдсан.	(252,000) ОХШХ-ийн Агаарын чанарын биелэлтийн зардалд тусгагдсан.
2			Орчны агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй байхын тулд ажилчдад тээврийн хэрэгслүүдийг шаардлагагүй тохиолдолд унтрааж байх, эвдрэл гэмтлийг тухай бүрт нь засварлах зэрэг зөвлөгөөг өгдөг.	-	-
3			Үйлдвэрийн хашааг зүлэгжүүлэх, тээврийн хэрэгсэл байнга зорчдог хэсгүүдийг хайрган болон хатуу хучилттай болгох, тохиромжтой газруудад мод тарих зэрэг орчны тоосжилтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.	Өвөл, хаврын улиралд үйлдвэрийн хашаан дахь цасыг арилгалгүй үлдээж; зун, намрын улиралд борооны усыг хуримтлуулан усалгаанд ашигладаг.	
<b>Дуу шуугиан</b>					
1	Үйлдвэрийн дотоод орчны дуу шуугиан ажилчдын сонголд нөлөөлөх	Үйлдвэрийн дотоод орчны дуу шуугианыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Үйлдвэрийн дотоод орчны дуу шуугианы түвшинг Цаг уур орчны шинжилгээний газрын “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”-иор хэмжилт хийлгэсэн ба 40 дБА буюу MNS 4585:2016 стандартын ЗДХ болох 60 дБА-ээс бага байна.	Тус тайлангийн ОХШХ-ийн Дуу шуугианы биелэлтийн зардалд тусгагдсан. (198,000)	
2		Ажилчдыг сонголд шалгах эмчийн үзлэгт хамруулах /Дуу чимээний түвшин 85дБа-гаас	Үйлдвэрийн дотоод орчны дуу шуугианы түвшин өдрийн цагаар		

#	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
		давсан үед ажиллагсдыг сонсголын хамгаалалттай оруулах/	стандартын ЗДХ-нээс бага хэдий ч ажилчдыг сонсгол хамгаалах хэрэгслээр /чихний бөглөө/ хангаж, үйлдвэр дотор ажиллаж байх хугацаандаа тогтмол хэрэглэхийг зөвлөдөг.		
<b>Гадаргын болон газрын доорх ус</b>					
1	Газрын доорх усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Цэвэр усны зохисгүй хэрэглээг зогсоох, ажилчдад ус хэмнэх арга, ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах	Ажилчдад сургалт зохион байгуулсан. Самрын үйлдвэр нь зөвхөн ажилчдын унданд зориулж ус хэрэглэдэг ба ундны усыг 1 тн-ын саваар “Жэ эйч жэй мандухай” ХХК-ийн гүний худгаас зөөвөрлөн хангадаг. “Жэ эйч жэй мандухай” ХХК нь усны хэрэглээг хянаж, бууруулахын тулд худгийн тоолуурыг шинэчилэн суурилуулж, баталгаажуулалтыг Стандарт хэмжилзүйн газраар хийлгэсэн байна. Мөн ажилчдад уух зориулалтаар үйлдвэрийн цэвэр ус худалдан авдаг.	Гүний худаг нь “Жэ эйч жэй мандухай” ХХК-ийн эзэмшлийнх тул тоолуурын үнэ болон баталгаажуулалтын төлбөрийг тус компани хариуцан гүйцэтгүүлсэн.	
<b>Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг</b>					
1	Үйлдвэрийн эдэлбэр газрын барилгажаагүй талбайн газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүний үйл ажиллагаагаар доройтох	Үйлдвэрийн эдэлбэр газрын барилгажаагүй талбайн газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөгийг хамгаалах, доройтлоос сэргийлэх	Үйлдвэрийн хашаан дахь зүлэгжүүлэх талбайг борооны ус хуримтлуулан усалж, хог хаягдлыг цэвэрлэн, тээврийн хэрэгсэл байнга зорчдог хэсгүүдийг хайрган болон хатуу хучилттай болгож, тохиромжтой газруудад мод тарих зэргээр талбайн хөрс, ургамлан нөмрөг, газрын гадаргыг хамгаалж байна.	(862,500) Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлтийн зардалд багтсан.	
2			Үйлдвэрийн эдэлбэр газрын ургамлын төлөв байдлын тойм судалгааг мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлсэн.	800,000	800,000
<b>Ойн сан</b>					

#	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1	Ойн дагалт баялгийг үйлдвэрийн зориулалтаар ашиглаж байна	БОУАӨ-ийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/737 дугаар тушаалын хавсралт. Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах	2022 оны 3 сарын 2 нд “Дүгэрээ нарс Петомник ХХК”-тай 5 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Сэлэнгэ аймгийн Дүгэрээ нарс гэх газарт 2 га талбайд хуш, нарс, шинэс зэрэг шилмүүст модддыг үрээр тарьж ургуулан, арчилгаа тордолт хийхэд хамтран ажиллаж байна.	Нэхэмжлэхийн дагуу төлбөрийг төлнө.	Нэхэмжлэхийн дагуу төлбөрийг төлнө.
2			Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/737 дугаар тушаалын хавсралт “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 3.4-т “Хуш модны самрыг 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргэл хугацаанд бэлтгэнэ” гэж заасан. Зөвшөөрлийн хугацаанд самрын нөөц багассан тул 2024 онд дуудлага худалдаанд оролцоогүй ба үйлдвэр үйл ажиллагаа явуулаагүй.	-	-
<b>Нийт дүн, төг.</b>					<b>800,000</b>

### 2.1.1 Агаарын чанар

- Орчны тоосжилт болон агаар дахь түгээмэл бохирдуулагч бодисуудын хэмжээг хянаж, бууруулахын тулд ОХШХ-ийн дагуу Агаарын чанарын дээж авах, шинжлүүлэх ажлыг Цаг уур орчны шинжилгээний газрын “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”-р гүйцэтгүүлсэн.

ОХШХ-т тусгагдсаны дагуу агаар дахь түгээмэл бохирдуулагч бодисууд болох азотын давхар исэл (NO<sub>2</sub>), хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), нийт тоосонцор (TSP)-ын агууламжийг үйлдвэрийн талбайд 2 цэгээс дээж авч, Цаг уур орчны шинжилгээний газрын “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”-д шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага болон MNS 4990:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ стандартын хүлцэх агууламжтай харьцуулан, тус тайлангийн ОХШХ-ийн биелэлтийн хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

- Орчны агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй байхын тулд ажилчдад тээврийн хэрэгслүүдийг шаардлагагүй тохиолдолд унтрааж байх, эвдрэл гэмтлийг тухай бүрт нь засварлах зэрэг зөвлөгөөг өгдөг.
- Үйлдвэрийн хашааг зүлэгжүүлэх, тээврийн хэрэгсэл байнга зорчдог хэсгүүдийг хайрган болон хатуу хучилттай болгох, тохиромжтой газруудад мод тарих зэрэг орчны тоосжилтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Усалгаанд өвөл, хаврын улиралд үйлдвэрийн хашаан дахь цасыг арилгалгүй үлдээж, зун, намрын улиралд борооны усыг хуримтлуулан ашигладаг.

**Гэрэл зураг 2.1 Тээврийн хэрэгсэл байнга зорчдог хэсгүүдийг хайрган болон хатуу хучилттай болгосон байдал**



### 2.1.2 Дуу шуугиан

- Үйлдвэрийн дотоод орчны дуу шуугианы түвшинг Цаг уур орчны шинжилгээний газрын “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”-иор хэмжилт хийлгэсэн ба 40 дБА буюу MNS 4585:2016 стандартын ЗДХ болох 60 дБА-ээс бага байна.

- Үйлдвэрийн дотоод орчны дуу шуугианы түвшин өдрийн цагаар стандартын ЗДХ-нээс бага хэдий ч ажилчдыг сонсгол хамгаалах хэрэгслээр (чихний бөглөө) хангаж, үйлдвэр дотор ажиллаж байх хугацаандаа тогтмол хэрэглэхийг зөвлөдөг.

### 2.1.3 Гадаргын болон газрын доорх ус

- Цэвэр усны зохисгүй хэрэглээг зогсоох, ажилчдад ус хэмнэх арга, ач холбогдлын талаар сургалт зохион байгуулсан.
- Самрын үйлдвэр нь зөвхөн ажилчдын унданд зориулж ус хэрэглэдэг ба ундны усыг 1 тн-ын саваар “Жэ эйч жэй мандухай” ХХК-ийн гүний худгаас зөөвөрлөн хангадаг. “Жэ эйч жэй мандухай” ХХК нь усны хэрэглээг хянаж, бууруулахын тулд худгийн тоолуурыг шинэчилэн суурилуулж, баталгаажуулалтыг Стандарт хэмжилзүйн газраар хийлгэсэн байна. Мөн ажилчдад уух зориулалтаар үйлдвэрийн цэвэр ус худалдан авдаг.

### 2.1.4 Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг

- Үйлдвэрийн хашаан дахь барилгажаагүй талбайг борооны ус хуримтлуулан усалж, хог хаягдлыг цэвэрлэн, тээврийн хэрэгсэл байнга зорчдог хэсгүүдийг хайрган болон хатуу хучилттай болгож, тохиромжтой газруудад мод тарих зэргээр талбайн газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөгийг доройтохоос хамгаалж байна. Тус арга хэмжээг орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлтийн хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

Гэрэл зураг 2.2 Зүлэгжүүлсэн болон хатуу хучилттай болгосон талбайнууд



- Үйлдвэрийн эдэлбэр газрын ургамлын төлөв байдлын тойм судалгааг байгаль орчны мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлсэн.

Үйлдвэрийн эдэлбэр газрын ургамлын төлөв байдлыг илэрхийлж чадахуйц 3 цэгт хээрийн бичиглэл хийсэн. “Хуш модны самар боловсруулах” үйлдвэр нь Улаанбаатар хотод байрладаг ба Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарагдана. Үйлдвэрийн талбайд жижиг үетэн-алаг өвст ургамлын хэвшинж зонхилсон ба ургамлын бүрхэц дунджаар 80-90%, зүйлийн олон янз байдал сайн буюу 10 м<sup>2</sup> талбайд 10-15 зүйл ургамал тархсан ба ургамлын дундаж өндөр 20-25 см байна.

Гэрэл зураг 2.3 Ургамлын бичиглэл хийсэн талбай



### 2.1.5 Ойн сан

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/737 дугаар тушаалын хавсралт “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 6.3-т *Хуш модны самрын нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн хуулийн этгээд бэлтгэсэн нөөцийнхөө 15,000 кг буюу 1.5 тн тутамд 1.0 га талбайд өөрийн хөрөнгөөр хуш модны тарьц суулгацаар нөхөн сэргээлт хийх эсхүл мэргэжлийн байгууллагаар хийлгэж, тухайн сумын Засаг даргын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгнө*” гэж заасан.

Манай үйлдвэр жилд 3000 тн байгалийн самар боловсруулах хүчин чадалтай ба тус журмын хэрэгжилтийг хангаж ажиллахаар 2022 онд “Дүгэрээ нарс Петомник ХХК”-тай 5 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээг байгуулан, Сэлэнгэ аймгийн Дүгэрээ нарс гэх газарт 2 га талбайд хуш, нарс, шинэс зэрэг шилмүүст моддыг үрээр тарьж ургуулан, арчилгаа тордолт хийхэд хамтран ажиллаж байна. “Дүгэрээ нарс Петомник ХХК”-тай байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тайлангийн хавсралтаар үзүүлсэн.

Гэрэл зураг 2.4 Шилмүүст модыг хүлэмжинд үрээр тарьж, гадна талбайд шилжүүлэн суулгасан байдал



### 3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Газрын тухай хуулийн 56.6-д “Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана” гэж заасан тул үйлдвэрийн барилгажаагүй талбайг зүлэгжүүлж, тохиромжтой газруудад мод тарьсан. 2024 онд үйлдвэрийн хашаанд 120 ш хайлаасны суулгац суулгаж, хайлаасыг үрээр тарьсан.

#### Хүснэгт 3.1 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

#	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг.,	Нийт зардал, төг.
1	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 50 ш хайлаас мод тарина.	Үйлдвэрийн хашаанд 120 ш хайлаасны суулгац суулгаж, хайлаасыг үрээр тарьсан. Модны арчилгаа тордолтыг тогтмол хийж байна.	4,700	562,500
2		Үйлдвэрийн хашаан дахь барилгажаагүй талбайг борооны ус хуримтлуулан усалж, хог хаягдлыг цэвэрлэн, тээврийн хэрэгсэл байнга зорчдог хэсгүүдийг хайрган болон хатуу хучилттай болгож, тохиромжтой газруудад мод тарих зэргээр талбайн газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөгийг доройтохоос хамгаалж байна	-	-

#	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг,	Нийт зардал, төг.
3	Хөрс болон модны нүх бэлтгэх	Мод тарих нүхнүүдийг урьдчилан бэлтгэж, үржил шимт хөрс худалдан авсан.	300,000	300,000
<b>Нийт дун, төг.</b>			<b>862,500</b>	

Гэрэл зураг 3.1 Зүлэгжүүлсэн талбай болон үрээр тарьсан хайлаас





#### 4 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

##### Хүснэгт 4.1 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

#	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг.	Нийт зардал, төг
1	Археологийн дурсгал	Хэрэв барилга байгууламж барих зэрэг газар шорооны ажлын үед археологи, палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд ажлаа зогсоож, тухайн дүүргийн засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.	Үйлдвэрийн эдэлбэр газарт түүх, соёлын биет өв илрээгүй.	Зардал төлөвлөөгүй	Зардал төлөвлөөгүй
2	Палеонтологийн дурсгал				
<b>Нийт дүн, төг.</b>					-

#### 5 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

##### Хүснэгт 5.1 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

#	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг.	Нийт зардал, төг
1	ХХАА-ны дүрэм журам зөрчигдөж үйлдвэрийн осол гарах	Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх чадварыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг хяналтын өрөө эсвэл ажлын байранд ил харагдахаар газарт байрлуулах	Ажилчдад ослын үед цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх зорилгоор анхны тусламжийн эмийн санг нүдэнд ил харагдахаар газарт байрлуулж, бүх ажилтнуудад байршлыг мэдээлсэн.	50,000	50,000
2		ХАБЭА-н дүрэм, заавар, журам боловсруулж ажилчдад танилцуулах, дүрэм, зааврыг мөрдүүлэх дотоод хяналт тавих	Байгууллагын ХАБЭА-н хэлтэсээс аливаа осол, эрсдэлийн үед “Анхны тусламж”-ийг зөв үзүүлэх дадал суулгах сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулсан.	50,000	50,000
3		Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ /ХАБ-ын булан, санамж, плакат, галын булан г.м/	Үйлдвэр тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа үед байгууллагын ХАБЭА-н мэргэжилтнүүд үйлдвэрийн нийт ажилчдад ахуйн болон	-	-

#	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг.	Нийт зардал, төг
			Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх зааварчилгааг өдөр бүр ажил эхлэхийн өмнө өгч, 14 хоногт тутамд сургалтыг тогтмол хийдэг.		
4			Аюул, осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хороо, дүүргийн хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардалд багтсан	Үйл ажиллагааны зардалд багтсан
5	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аварга өртөх	Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдаж авах (галын хор, гал унтраагч, ус цацагч гэх мэт)	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байршуулсан.	100,000	100,000
6		Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Байгалийн гамшигийг даван туулах болон үйлдвэрийн, ахуйн аливаа ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг ажилчдад таниулах сургалт зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардалд багтсан	Үйл ажиллагааны зардалд багтсан
7		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Ажилчдад галын хор болон бусад хэрэгслийг хэрхэн зөв оновчтой ашиглах зааварчилгааг өгч, дадал суулгах сургалтыг улирал тутам орж байна.	Үйл ажиллагааны зардалд багтсан	Үйл ажиллагааны зардалд багтсан
<b>Нийт дүн, төг.</b>					<b>200,000</b>

## 6 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### Хүснэгт 6.1 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

#	Хог хаягдлын ангилал	2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг,	Нийт зардал, төг,	Тайлбар
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис цацаж тогтмол ариутгаж байх	Сан хими ХХК-тай 2022-2025 оны 9.19 хүртэл гэрээ байгуулсан. 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй тул нэг удаа ариутгал хийлгэсэн.	500,000 Гэрээний дүнгээр төлсөн	500,000 Гэрээний дүнгээр төлсөн	Гэрээний дугаар 22/037.
2		Дахин боловсруулах боломжгүй хаягдлыг дүүргийн тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу зөвшөөрөгдсөн хаягдлын цэг рүү тээвэрлэн хүргүүлж, хог хаягдлын төлбөр тооцоог тогтсон хугацаанд төлж байх	Сонгинохайрхан дүүрэг болон тус дүүргийн хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөл бүхий Эко эрин ХХК-тай “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах, тээвэрлэх” гурвалсан гэрээ байгуулсан. Тус гэрээний дагуу үйлчилгээний хураамжийг төлж, хог хаягдлыг тээвэрлүүлж байна.	400,000 Гэрээний дүнгээр төлсөн	400,000 Гэрээний дүнгээр төлсөн	Гэрээний дугаар:350 Гэрээг хавсралтаар үзүүлсэн.
3	Шингэн хаягдал	Үйлдвэрийн ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдлыг бохир ус зайлуулах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан зайлуулах	Самрын үйлдвэр нь зөвхөн ажилчдын ундны зориулалтаар ус хэрэглэдэг тул ахуйн бохир ус гардаггүй.	-	-	
4	Боловсруулсан самрын хаягдал буюу яс	Самрын хаягдал ясыг түлж халаалтад хэрэглэж бууруулахаас гадна самрын ясан дэр хийх зэргээр үйлдвэрийн хог хаягдлыг бууруулна.	Самрын ясан дэр хийхэд хамтран ажиллах хувь хүн, ААН-г судлаж байгаа, мөн самрын ясыг үртэс түлдэг зуух ашиглах боломжтойг судалсан.	-	-	
<b>Нийт дүн, төг.</b>					<b>900,000</b>	

## 7 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

## Хүснэгт 7.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

#	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	2024 онд хэрэгжүүлсэн БОМТ-ний ОХШХ-ийн хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төг.	Нийт зардал, төг.
1	Агаарын чанар	Нийт тоосонцор, SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>	Үйлдвэрийн дотор болон гадна	2024 онд 1 удаа	252,000	252,000
2		Дуу шуугиан, дБА	Үйлдвэрийн дотор болон гадна	2024 онд 1 удаа	198,000	198,000
3	Хөрсөн бүрхэвч	Хөрсний агрохими	Үйлдвэрийн хашаанд 1 цэгт	2024 онд 1 удаа	44,000	44,000
4		Хөрсөн дэх хүнд металлын агууламж тодорхойлох	Үйлдвэрийн хашаанд 1 цэгт	2024 онд 1 удаа	30,800	30,800
5	Газрын доорх ус	Химийн ерөнхий үзүүлэлтүүд	Самрын үйлдвэр нь зөвхөн ажилчдын унданд зориулж ус хэрэглэдэг ба ундны усыг 1 тн-ын саваар “Жэ эйч жэй мандухай” ХХК-ийн гүний худгаас зөөвөрлөн хангадаг. Иймд дээж авах усны эх үүсвэр байхгүй.	-	-	-
<b>Нийт дүн, төг.</b>						<b>524,800</b>

## 7.1.1 Агаарын чанар

2024 оны БОМТ-ний ОХШХ-т тусгагдсаны дагуу агаар дахь түгээмэл бохирдуулагч бодисууд болох азотын давхар исэл (NO<sub>2</sub>), хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), нийт тоосонцор (TSP)-ын агууламжийг үйлдвэрийн гадна талбайд болон үйлдвэр дотор гэсэн 2 цэгээс дээж авч, Цаг уур орчны шинжилгээний газрын “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”-д шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнгүүдийг харгалзах стандартын (MNS 4585:2016) хүлцэх агууламжтай харьцуулан дараах хэсэгт үзүүлээ.

Үйлдвэрийн гадна талбайн агаарын чанарын шинжилгээний үр дүнгээр Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)-н агууламж нь хэмжилт хийсэн цэгт MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжаас 442 мкг/м<sup>3</sup>-ээр бага, Азотын давхар исэл (NO<sub>2</sub>)-ийн агууламж 148 мкг/м<sup>3</sup>-ээр бага, нийт тоосонцорын агууламж 160 мкг/м<sup>3</sup>-ээр бага буюу бохирдолгүй байна.

**Хүснэгт 7.2 Үйлдвэрийн гадна талбайн агаарын чанарын шинжилгээний үр дүн, 2024.5.13**

#	Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хээрийн хэмжилтийн үр дүн (дундаж агууламж)	MNS 4585:2016 Хүлцэх агууламж
1	Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	20 минут	мкг/м <sup>3</sup>	8	450 (20 минутын дундаж)
2	Азотын давхар исэл NO <sub>2</sub>	20 минут	мкг/м <sup>3</sup>	52	200 (20 минутын дундаж)
3	Нийт тоосонцор	20 минут	мкг/м <sup>3</sup>	340	500 (20 минутын дундаж)

*Тайлбар:* MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

Үйлдвэрийн дотоод орчны буюу ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийн хувьд Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)-н агууламж MNS 4990:2023 стандартын ЗДХ-нээс 1.992 мг/м<sup>3</sup>-ээр бага, Азотын давхар исэл (NO<sub>2</sub>)-ийн агууламж 4.948 мг/м<sup>3</sup>-ээр бага, нийт тоосонцорын агууламж 9.66 мг/м<sup>3</sup>-ээр бага буюу бохирдолгүй байна.

**Хүснэгт 7.3 Үйлдвэрийн дотоод орчны агаарын чанарын хэмжилтийн үр дүн, 2024.5.13**

#	Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хээрийн хэмжилтийн үр дүн (дундаж агууламж)	MNS 4990:2023 8 ЦЖД өртөлтийн ЗДХ
1	Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	8 цаг	мг/м <sup>3</sup>	0.008	2
2	Азотын давхар исэл NO <sub>2</sub>	8 цаг	мг/м <sup>3</sup>	0.052	5
3	Нийт тоосонцор	8 цаг	мг/м <sup>3</sup>	0.340	10

*Тайлбар:* MNS 4990:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ 8 ЦЖД-8 цагт жиллэсэн дундаж өртөлтийн ЗДХ

**7.1.2 Дуу шуугиан**

Дуу шуугианы хэмжилтийг үйлдвэрийн хашаанд болон үйлдвэрийн дотор гэсэн 2 цэгт, зориулалтын багаж ашиглан өдрийн цагаар 4 цагийн турш хэмжсэн.

Дуу шуугианы дундаж утгуудыг MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулан зургаар үзүүллээ. Хэмжилтийг өдөр хийсэн тул уг стандартын өдөр (07-22 цаг)-ийн утгатай (60дБА) харьцуулав.

Үйлдвэрийн хашаанд хэмжсэн цэгт дуу шуугианы хэмжилтийн дундаж утга 38 дБА, үйлдвэр дотор 45 дБА буюу MNS 4585:2016 стандартын ЗДХ (60дБА)-нээс 15-22 дБА-ээр бага байна.

**Хүснэгт 7.4 Дуу шуугианы хэмжилтийн үр дүн**

Холбогдох стандарт	Дуу шуугианы түвшин	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ дБА	Хэмжилтийн үр дүн, дБА
MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	Өдөр (0700 - 2200)	60	38 (үйлдвэрийн хашаанд) 40 (үйлдвэр дотор)

### 7.1.3 Хөрсөн бүрхэвч

2024 оны БОМТ-ний ОХШХ-т тусгагдсаны дагуу хөрсний агрохимийн үзүүлэлтүүд болон хөрсөн дэх хүнд металлын агууламжийг тодорхойлох дээжүүдийг авч Грийн лаб ХХК-ийн Хөрс, усны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

#### 1. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд

**Хүснэгт 7.5 Хөрсний үржил шимийн үзүүлэлтүүд**

Цэгийн дугаар	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ ЕС 1:2.5, dS/m	Карбонат, CaCo%	Ялзмаг (орг.С), %	Шингээгдсэн сууриуд		Хөдөлгөөнт	
							Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub> , мг/100г	K <sub>2</sub> O, мг/100г
Ердийн хар шороон хөрс										
Дээж-1	0-20	8.26	0.02	0.047	0.00	1.80	18.0	2.8	2.4	29

Эх сурвалж: Грийн лаб ХХК-ийн Хөрс, усны лаборатори. 2024.5. Хөрсний задлан шинжилгээний үр дүн

**Хүснэгт 7.6 Хөрсний үржил шимийн суурь үзүүлэлтүүд ба шинжилгээний үр дүнгийн тайлбар**

Үржил шимийн үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	Шинжилгээний үр дүнгийн тайлбар
Хөрсний урвалын орчин (pH)	Хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг.	Хөрсний 0-20 см дэх pH-ийн утга 8.26 буюу сул шүлтлэг урвалын орчинтой байна.
Карбонат, %	Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10 % байхад тохиромжтой гэж үзнэ.	Шинжилгээний үр дүнгээс үзэхэд бүх дээжинд карбонат илрээгүй буюу карбонатжаагүй байна.
Ялзмаг, %	Хөрсийг ялзмагийн агууламжийг 5% бол их ялзмагтай гэж үнэлдэг.	Шинжилгээний үр дүнгээс үзэхэд 0-20 см дэх ялзмагийн агууламж 1.8%-ийн хооронд буюу бага агууламжтай.
Цахилгаан дамжуулах чанар ЕС 1:2.5, dS/m	Хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг.	Хөрсний цахилгаан дамжуулах чанар (ЕС 1:2.5) буюу хялбар уусах давсжилт (ЕС) бүх хэвшинжийн хөрсөнд 0.047 dS/m буюу давсархаг биш байна.
100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор P <sub>2</sub> O <sub>5</sub> , мг/100г	Хөрсний азот, фосфор, кали (N, P, K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог.	Шинжилгээний үр дүнгээс үзэхэд бүх дээжинд хөрсний P <sub>2</sub> O <sub>5</sub> -ын агууламж 2.4 мг/100г хооронд буюу дунд хангамжтай байна.
100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт кали K <sub>2</sub> O, мг/100г		Хөдөлгөөнт калийн хувьд 29 мг/100г хооронд буюу сайн хангамжтай байна.

#### 2. Хөрсөн дэх хүнд металлын агууламж

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд үйлдвэрийн хашаан дахь хөрсөнд агуулагдах хром (Cr), кадми (Cd), хар тугалга (Pb), зэс (Cu), никель (Ni), цайр (Zn) зэрэг хүнд металлуудын агууламж MNS

5850:2019<sup>1</sup> стандартын ЗДХ болон хортой, аюултай агууламжаас хэтэрсэн үзүүлэлт илрээгүй буюу хэвийн хэмжээнд байна. Шинжилгээний үр дүнг тус тайланд хавсаргав.

**Хүснэгт 7.7 Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн**

#	Элемент	Хэмжих нэгж	Дээж-1	MNS 5850:2019		
				ЗДХ	Хортой агууламж	Аюултай агууламж
1	Cd	мг/кг	-	3	10	20
2	Cr	мг/кг	49.2	150	400	1500
3	Cu	мг/кг	25.3	100	500	1000
4	Ni	мг/кг	32.7	150	1000	1800
5	Pb	мг/кг	28.2	100	500	1200
6	Zn	мг/кг	69.6	300	600	1000

*Эх сурвалж:* Грийн лаб ХХК-ийн Хөрс, усны лаборатори. 2024.5.30

<sup>1</sup>Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

## 8 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 8.1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

#	2024 оны БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд төлөвлөсөн ажлууд	2024 оны БОМТ-г хэрэгжүүлсэн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг.	Нийт зардал, төг.
